



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 95

Мандалговь

Г Ундсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтооолор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,372,074,024 /хоёр тэрбум гурван зуун далан хоёр сая далан дөрвөн мянга хорин дөрөв/ төгрөгийн санхүүжилтээр баригдсан Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилга, эд хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ж.Өлзийжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СУХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны дүгээр сарын  
08-ний өдрийн 25 тогтоолын хавсралт

**Дэлгэрхангай сум Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд  
бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	ДҮН
1	Сургуулийн барилга, 320 хүүхдийн суудалтай	м <sup>2</sup>	1470	1,085,622	1,595,863,775
2	Спорт заалны барилга	м <sup>2</sup>	648	860,955	557,898,956
3	Хүзүүвчний барилга	м <sup>2</sup>	120	1,115,504	133,860,440
4	Гүний худгийн барилга, Гүний худгийн насстой	м <sup>2</sup>	12	1,782,941	21,395,295
5	Зам талбай хашаа	м <sup>2</sup>	Зам талбай 555м <sup>2</sup> , хашаа 285м <sup>2</sup>	62,055,558	62,055,558
6	Гадна гэрэлтүүлэг	ш	5	200,000	1,000,000
<b>Нийт дүн</b>					<b>2,372,074,024 /хоёр тэрбум гурван зуун далан хоёр сая далан дөрвөн мянга хорин дөрөв/ төгрөг</b>